БАТЛАВ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА Ж.АЛТАНГЭРЭЛ

2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр

НАЛАЙХ ДҮҮРГИЙН 2 ДУГААР ХОРОО, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТТАЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03/02 дугаар тогтоол
2	Засварын ажлын нэр /төрөл/ байршил	Налайх дүүргийн 2 дугаар хорооны 47 дугаар байрны дээвэр
3	Төслийн захиалагч	Налайх дүүргийн ЗДТГ
4	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч болон гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5	Дээврийн засварын ажилд тавигдах шаардлага	Дээврийн ажил БНбД 31-07-05-д заасан технологийн дагуу засварын ажлыг гүйцэтгэнэ.
6	Материалд тавигдах шаардлага	Барьцалдуулагч материал нь засварын ажлын талбайд ойр байх ба +5^{0}С-аас багагүй температуртай байна. Тусгаарлалтын материал нь БНбД 31-07-05 /хүснэгт 1/-д заасан шаардлагыг хангасан байна.

Ажлын тоо хэмжээ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Дээврийн 15 мм зузаан цементен тэгшилгээ хийх	м^2	96.9
2	Дараагийн 1 мм зузаан тутамд үнэлгээ 30-д нэмэх	м^2	484.5
3	Чулуугүй цаасаар дээврийг бүрэх	м^2	387.6
4	Чулуутай цаасаар дээврийг бүрэх	м^2	387.6
5	Шахтны гадна хана шохойн будгаар гар аргаар будах	м^2	36
6	Барилгын гадна орчны хог 10 м^2 зайд зөөж цэвэрлэх, шүүрдэх	м^2	387.6
7	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд экскаватораар ачих	м^3	19.38

Захиалагч байгууллага:

- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлаглсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг баримтлана.

Гүйцэтгэгч байгууллага:

- Ажил эхлүүлэхдээ дүүргийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж, ажил гүйцэтгэх үе шатны график төлөвлөгөөг хүлээлгэн өгөх

- Барилгын хамгийн өндөр давхарын айл өрхүүдийн дотор талын ус нэвчсэн байдлыг ажил эхлэх үеэс өмнөх байдлаар баталгаажуулах
- Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын барилгын техникийн дотоод хяналтын жишиг дүрэм”-ийг мөрдөх
- Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын барилгын техникийн дотоод хяналтын жишиг дүрэм”-ийн гуравдугаар хавсралтаар батлагдсан “Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагын техникийн дотоод хяналт”-ыг гүйцэтгэх
- Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ыг мөрдөх
- Монгол улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”
- Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага /UCS0001-01:2019/-ыг мөрдөж ажиллах
- Гүйцэтгэгч байгууллага нь ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх
- Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагч болон захиалгчийн хяналтыг төлөөлөн гүйцэтгэх эрх бүхий этгээдийн заасан хугацаанд засварлаж өгөх
- Барилгын талбайгаас гарах хаягдлыг зайлуулахдаа “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай хог тээврийн гэрээ байгуулан зөвшөөрөгдсөн хогийн цэгт хог хаягдлыг хаях.

Барилгын материалд тавигдах шаардлага:

- Асбест буюу гидросиликат, магни, төмөр, кальци, натригаас тогтсон нарийн утсархаг бүтэцтэй бутрамтгай чулуулаг эрдэс бүхий барилгын материал ашиглахыг хатуу хориглоно.
- Гүйцэтгэгч нь импортын материал ашиглах нөхцөлд газар үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байх.
- Үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах нөхцөлд “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” лабораторийн шинжилгээний дүнг хавсаргаж ирүүлнэ.

Дээрх ажлын даалгаварт заасан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч болон захиалагчийн хяналтыг төлөөлөн гүйцэтгэх эрх бүхий этгээд, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Боловсруулсан: Захирагчийн Ажлын албаны
Хот төлөвлөлт, барилга байгууламж, сууц өмчлөгчдийн холбоо хариуцсан мэргэжилтэн
Б.Галмөнх